

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ, МЭДЭЭЛЭЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛУУД

Японы милитаризмыг ялсны 40 жилийн ойг манай оронд өргөн тэмдэглэсэн бөгөөд ойд зориулж 1985 оны 8-р сарын 20-нд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институт, Намын дээд сургууль, Монголын ардын армийн улс төрийн газар, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхлэн эрдэм шинжилгээний бага хурал хийлээ.

Бага хуралд БНМАУ-ын Батлан хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, хошууч генерал Д.Гэндэнпил “Японы милитаризмыг ялсны түүхэн ач холбогдол”, Зөвлөлтийн армийн хошууч генерал А.В.Терентьев “Японы милитаризмын эсрэг явуулсан дайнд зөвлөлтийн цэргийн урлаг хөгжсөн нь” сэдвээр илтгэл тавьж, илтгэлүүдтэй холбогдуулан МАХН-ын Төв Хорооны дэргэдэх НДС-ийн багш доцент П.Дорж, БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний институтын захирал, дэд эрдэмтэн хурандаа Д.Гомбосүрэн, Зөвлөлтийн армийн хошууч генерал А.Ф.Картанов, ШУА-ийн ДДСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд эрдэмтэн Л.Хайсандай зэрэг хүмүүс үг хэлж, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хошууч генерал Ч.Данзан Д.Дамдинхүү нар дурдатгалаа ярив.

Нөхөр Д.Гэндэнпил илтгэлдээ, Японы милитаристууд эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд дэлхийн дайн бүрд эртнээс бэлтгэж 1931 онд Зүүн хойд Хятадыг эзэлж, ЗСБНХУ, БНМАУ-ын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд нэг биш удаа халдан довтолж, бутцохигдож байсан билээ.

Милитарист Япон цэрэг эдийн засаг, улс төрийн талаа удаан хугацааны турш бэлтгэсэн Хасан нуур, Халхын голын байлдаанд ялагдаж, Москва, Сталинградын дэргэд фашистын Германы цэрэг бутцохигдсон нь түүнээс ЗСБНХУ, БНМАУ-д довтолох төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд мгол саад тогтор болжээ.

Холбоотныхоо үүрэгт үнэнч ЗСБНХУ 1945 оны 8-р сарын 9-нд милитарист Японы эсрэг дайнд орсон нь Алс Дорнодын аюулгүй байдлыг хангах, бат бэх энх тайван тогтоох, дэлхийн II дайныг түргэн дуусгах, Японы түрэмгийлэгчдийн хууль бусаар булаан эзэлсэн нутаг дэвсгэрт ЗХУ-ын эрхийг сэргээн тогтоох зорлиготой байв.

БНМАУ нийтийн дайсныг дарах шудрага үйл хэрэгт өөрийн хувь оруулах зорилгоор 1945 оны 8-р сарын 10-нд Японы эсрэг дайн зарласан юм.

Фашизм, милитаризмыг ялахад ЗХУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж 1945 оны 9-р сарын 2-нд милитарист Япон үг дуугүй бууж өгөх тухай баримт бичигт гарын үсэг зурснаар дэлхийн II дайн дуусч, асар их үнэ цэнээр энх тайвныг тогтоосон тухай ярив.

Зөвлөлтйн армийн хошууч генерал А.В.Терентьев хавсралт илтгэлдээ Германы фашизмыг бутцохиж, Европт энх тайвныг тогтоосон Зөвлөлтийн ард түмний өмнө Дорно дахины ард түмнийг чөлөөлж, улмаар дэлхийн дайны голомтыг бүрэн устгах явдал зайлшгүй чухал болсноор ЗХУ шудрага дайнд орж Японы милитаризмыг бутцохиж Азид энх тайвныг тогтоон бататгахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм гэв.

Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн хамтарсан Гэгээрлийн бага хурал 8-р сарын 15-нд болов. Гэгээрлийн бага хуралд Дорнодахины судлалын хүрээлэнгийн секторын эрхлэгч Э.Пунцаг, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баатар нар илтгэл тавьж, Зөвлөлт, Монголын арми Зүүн хойд Хятад, Өвөр Монголыг Японы милитаристуудаас чөлөөлсөн тухай болон түүний ач хобогдолыг онцлон тэмдэглэв.

Гэгээрлийн бага хуралд БНХАУ-аас БНМАУ-д суугаа ЭСЯ-ны хариуцлагатай ажилтнууд оролцож үг хэлэв.

* * *

9-р сарын 2-нд ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгээс зохион явуулсан эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурлыг ШУА-ийн ДДСХ-ийн захирал, сурвалжлагч гишүүн Н.Ишжамц нээж, “Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их гамшиг зовлон учруулсан дэлхийн II дайн дууссанаас хойш 40 жил болж дэлхийн улс түмэн шинэ дайны аюул заналд нэрвэгдэлгүй 40 жил аж төрж, энх тайвны ариун үйлс ялан мандсаар ирлээ. Гэвч АНУ тэргүүтэй империалист харгис хүчний гэм буруугаар өнөө үед олон улсын байдал ихээхэн хурцдаж цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулахын тул энхийг эрхэмлэгч нийт хүчин үйл ажиллагаа, хүч чармайлтаа нэгтгэх явдал амин чухал асуудал болсон ийм үед Японы милитаризмыг ялсны 40 жилийн ойг тэмдэглэж, уг ойд зориулсан онол-практикийн бага хурал хийж байна гээд дэлхийн II дайны төгсгөлийн шатанд Азийн эх газар дахь Японы милитразмын гол хүч Квантуны армийг бутцохиж, Зүүн хойд Хятад, Өвөр Монголыг чөлөөлөхөд Монгол Ардын Хувьсгалт арми, ах дүү ЗХУ-ын Улаан армийн дайчидтай мөр зэрэгцэн явж чухал хувь нэмэх оруулсан юм.

Энэ ялалтыг ЗХУ-ын коммунист нам, МАХН удирдан чиглүүлсэн юм” гэж цохон тэмдэглэв. Н.Ишжамц цааш нь хэлэхдээ, Дорно зүгт Японы милитразмыг ялсны үр дүнд Ази, Номхон далайн олон зуун сая ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэрээн мандуулж энх тайван, хөгжил дэвшлийн замаар орсон билээ гэв.

Германы фашизм Японы милитразмыг ялсны 40 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолд тэмдэглэхдээ дэлхийн II дайнд зөвлөлтий ард түмний хийсэн түүхэн ялалт дэлхийн хөгжлийн бүхий л явцад хувьсгалжуулагч гүн гүнзгий нөлөө үзүүлснийг дурдаад, “Дэлхийн хоёрдугаар дайны түүхэн сургамж нь олон улсын империализмын түрэмгий хүч, дайны хэнээтнүүдэд хатуу сануулга болж байна. Хамгийн гол сургамж нь дайн гарахаас урдаж энх тайвны төлөө тэмцэх хэрэгтэй юм”. Үнэхээр дайныг эхлээгүй дээр нь зогсоох асуудал орчин үеийн хойшлуулшгүй зорилт билээ. Чухам ийм учраас өнгөрсөн дайны ялалтын

үр дүнд, сургамж өнөө үеийн тулгамдсан асуудлыг зүй зохистойгоор шийдвэрлэхэд нэн чухал ач холбогдолтой болж байна. “Дэлхийн янз бүрийн районы 50 сая хүний амь насыг бүрэлгэн сүйтгэсэн өнгөрөгч дайн шиг тийм аюул хүн төрөлхтөнийг дахин нөмрөх ёсгүй”. Гэтэл империалист, жанжлагч хүчнүүд улам ойртон сүлбэлдэж, Японд милитаризмыг сэргээх явдал идэвхжиж, Вашингтон-Токио-Сеулийн цэрэг-улс төрийн түрэмгий эвслийг бий болгож байгаа нь зөвхөн Ази, Алс Дорнодоор төдийгүй, даян дэлхийн энх тайван үйлсэд ноцтой занал учруулж байна.

Иймд нөхцөлд ах дүү ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны энх тайванч санал, санаачлага, түүний дотох Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэргэлэх конвенц байгуулах тухай БНМАУ-ын дэвшүүлсэн санал болон энэ зорилгоор Азийн орнуудын уулзалт хийхийн чухлыг тэмдэглэсэн МАХН-ын XVIII их хурлын заалт цаг үеийн чухал ач холбогдолтой нь мэдээж юм.

Хөрөнгөтний үзэл сурталчид дэлхийн II дайны түүх, түүний дотохр Японы милитаризмыг ялсны түүхий мушгин гуйвуулах оролдлого гаргасаар ирсэн бөгөөд одоо ч тийм хандлага үргэлжлүүлсээр байна. Тэд Японы милитаризмыг ялахад гүйцэтгэсэн ЗХУ-ын шийдвэрлэх үүргийн бууруулах буюу үгүйсгэж, түүхийг завхруулах оролдлогоо идэвхжүүлж байгаа боловч түүхийн хүрдийг буцааж чадахгүй тухай фашизм, милитаризмыг энх тайван, социализмын хүч ялсан түүхтэй бөгөөд энх тайван, социализмын үйл хэрэг хэзээ ч ялан мандах тухай тэр үгийнхээ төгсгөлд онцлон тэмдэглэв.

Уг хуралд “Дорнодахины судлалын асуудал” сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга, дэд эрдэмтэн С.Ишдорж “Японы милитаризмыг ялсны түүхан ач холбогдол, орчин үе” илтгэл тавьж, секторын эрхлэгч Э.Пунцаг “Японы милитаризмыг ялахад ЗХУ-ын оруулсан хувь нэмрийг үнэлэх асуудлаар сонсгол хийв.

Бага хуралд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Ринчэн “Дэлхийн II дайнд БНМАУ-ын оруулсан хувь нэмэр”, МАХН-ын Төв хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институтын эрдэм шинжилгээний ажилтан, дэд эрдэмтэн Л.Оюунгэрэл “Хөрөнгөтний түүх гуйвуулга” ДДСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Л.Бэгзжав “Дэлхийн II дайны түүхийн зарим асуудлыг БНХАУ-д үзэж байгаа байдал” сэдвээр тус тус үг хэлэв.

Уг хуралд ДДСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Хандсүрэн Квантуны армийн “731”-р отряд гэгчийн тухай сонирхолтой мэдээлэл хийв. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, дэд хурандаа, зураач Б.Равсал Японы эсрэн 1945 оны дайнд оролцож явсан тухай сонирхолтой дурсамж ярилаа.

Хуралд оролцогчид өнгөрсөн дайны сургамжийг анхааран үзэж, цөмийн дайн гарах аюулыг өнөө болон хойч үеийнхний амьдралаас зайлуулах, зэвсэглэлээр хөөцөлдөхийн зогсоож, пуужин цөмийн зэвсгийг сансарт дэлгэрүүлэхээс сэрэмжилж, олон улсын харилцааг тэгш эрх, харилцан ашигтайгаар хамтран ажиллах замд эргүүлэн оруулахын тулд нэн даруй үр нөлөөтэй арга хэмжээ авахыг хүн төрөлхтөний амин чухал эрх ашиг шаардаж байгааг цохон тэмдэглэв.

Ч.Батцэцэг